



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Мон-Девелопмент ХХК-ийн “Вайт хаус” зочид буудлын 17/120, Тэгш центр ХХК-ийн “Тэгш” дэн буудлын 17/090, Хос хүч ХХК-ийн “Хаш” дэн буудлын 17/091, Гоо билэгүүд ХХК-ийн “Таац” дэн буудлын

17/106, Трикларс треже ХХК-ийн “Гурван өнгө” дэн буудлын 17/116, Батхаан групп ХХК-ийн “Батхаан” амралтын газрын 17/107 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

5284325 СБТ 48936 1118203502

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 24 өдрийн А/42 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284025 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.24

Улаанбаатар хот

Д/ А	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мон девелопмент ХХК	2804433	Вайт хаус	БГД-ийн 17-р хороо Амарсанаагийн гудамж
2	Наран саран ХХК	5007868	Рич	ЧД-ийн 6-р хороо 6-р хороолол их тойруу
3	Цэцэн хангай ХХК	2064561	Цэцэн хангай	БЗД-ийн 6-р хороо ЭТӨЧ

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 24 өдрийн А/42 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.24

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тэгш центр ХХК	5909503	Тэгш	СХД-ийн 11-р хороо хонхорын 1-13
2	Хос хүч ХХК	2589818	Хаш	БЗД-ийн 6-р хороо 13а
3	Гоо билэгүүд ХХК	5436354	Таац	БГД-ийн 22-р хороо зүүн наран 18-70
4	Трикларс треже ХХК	5513367	Гурван өнгө	БГД-ийн 6-р хороо Ард Аюушийн өргөн чөлөө гудамж 76-2
5	Гантех сервис ХХК	2574756	Шинэ энерги	БГД-ийн 4-р хороо Замчдын гудамж 15
6	Мега тур ХХК	5785251	Сара гэст хаус	ЧД-ийн 4-р хороо Бага тойруу зоос гоёл 203

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 24 өдрийн А/42 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284025 СБТ 8936 1118203502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.24

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Батхаан групп ХХК	2027968	Батхаан	СХД-ийн 24-р хороо баруун салаа бумбатын ам
2	Их хайрхан тур ХХК	2672073	Их хайрхан	БЗД-ийн 20-р хороо Гачуурт тосгон хар усан тохой 294
3	Чингисийн өвөр ХХК	6207383	Чин чандмань	НД-ийн 6-р хороо Горхи тэрэлж Чингис уулын өвөр

-ooOoo-